

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-8</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>3-8</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 19-ний өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63,2 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 28 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, Б.Чойжилсүрэн.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ш.Раднаасэд, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Засгийн газрын өрийн нийт хэмжээг 2024-2026 онуудад “60 хувь” гэснийг “51

хувь” болгож бууруулах. Үүнийг дагалдуулан мөнгөн дүнг бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
26.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 09 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
09 цаг 28 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Нийт Байнгын хорооны 19 гишүүн хуралдаанд оролцохоос 11 гишүүн ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн миний бие, Ганибалын Амартүвшин, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал, Жамбын Батсуурь, Хүрэлбаатарын Булгантуяа, Болдын Жавхлан, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн, Чимэдийн Хүрэлбаатар гэсэн ирцтэйгээр Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны өнөөдрийн 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүний танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бадамрагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсанванданы Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Байгалмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэсэн байгаа.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын

зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Асуулттай гишүүд байна уу. Батжаргал гишүүний нэрийг оруулъя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл орж ирж байгаа юм. Тэгээд энэ мэдээж бид нар энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудын дагуу үндсэн үзүүлэлтүүдийн хязгаарын тухай асуудал яригдаж байгаа нь ойлгомжтой. Гэхдээ мэдээж зардлын ангилал төсөл арга хэмжээний ерөнхий төсөөлөл авагдаж, энэ тоон асуудлууд гарч ирэх нь ойлгомжтой. Тийм учраас бид нарын гол бас зардлын нэг том эзлээд байдаг зүйл бол энэ хүүхдийн мөнгөний асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр зэрэг 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлд энэ хүүхдийн мөнгө ер нь ямархуу байдлаар тооцогдож, аль ангиллаасаа олгогдохоор хэдий хэмжээний хөрөнгө байна гэж ер нь тусаж орж байна вэ. Энэ дээр нэг тов тодорхой мэдээлэл авмаар байна.

2 дугаарт өчигдөр ч би ярьсан. Бид нарын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт жилээс жилд тодорхой өсөлтийнхөө хувиар өсөөд яваад байгаа. Тийм учраас одоо байж байгаа манай өрийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 51 хувьтай гэж бид нарын тоо тов тодорхой гарч ирж байгаа. Тэгэхээр тусгай шаардлагынхаа дагуу 60 дотор байж болно гээд 60-аар тавьчихаад орж ирээд байгаа энэ нийгэмд их буруу мэдээлэл өгөгдөөд болж өгөхгүй байгаа.

Тийм учраас одоо байж байгаа суурь түвшин тэр дээр 2024 оны хэрэгцээний төсөөлөл энэ 2-ыг харгалзахаар зэрэг яг ер нь үндсэндээ нийт бүтээгдэхүүний хэдэн хувь байхаар төсөөлөгдөж байгаа юм бэ. Одоо энэ орж ирсэн материал дээр бол бараг 49 хувьд баригдахаар юм байна гэсэн ийм юм уншигдаад байгаа. Тэгэхээр зэрэг үүнийг бодитой тавьчихаж болохгүй юм

уу хэдүүлээ. Энэ бол бас цаанаа тийм улс төрийн учир шалтгаантай үзүүлэлт шүү. Тийм учраас энэ дээр нэг тодорхой тайлбар авмаар байна.

Ер нь бол одоо бид бүрдүүлдэг юм зарцуулдаг юм хоёроо нэлээн зөв зохистой харж, тэгээд тэр дээрээ тулгуурлаж аль болохоор алдагдал багатай, өөр эх үүсвэр хайж өрөө нэмэгдүүлдэг биш тийм төсөв батлах зарчмаа барьж явах ёстой. Энийг манай Засгийн газар бол ер нь бас сүүлийн 2 жил нэлээн барьж тэр тусгай шаардлагаар тавигдаж байгаа үзүүлэлтүүдээсээ бууруулж орж ирээд батлуулаад яваад байсан. Тэгэхээр 2024 оныхоо төсвийн хүрээний мэдэгдэл дотроо энэ хувь процентоо ер нь барьж ирсэн тэр бодлогын залгамж чанараа хангаж, доош нь буулгах ер нь бололцоо боломж байна уу. Би бол яг мөнгөн хөрөнгийнх нь биет хэмжээгээр 1,4 их наядаас л дотоги оруулж бид батлах ёстой. Ер нь төсвөө бол. Гэхдээ төсвийн хүрээний мэдэгдлээ ч гэсэн тийм хязгаартай хийж өгч байж төсөв боловсруулахад ерөнхий барих зарчим нь зөв болох юм байна гэсэн ийм байр суурьтай байна. Энэ дээр одоо бас тодорхой хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Бүгдэд нь өглөөний мэнд. Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн мөнгөний хувьд бид тэнцвэржүүлсэн төсөл дээрээ 100 хувь төсөвлөсөн байгаа.

2 дугаарт өрийн хувьд энэ бол хязгаарын тоо. Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол бид хязгаарынхаа тоог л батлуулдаг. Гүйцэтгэл бол бид төсвөө өргөн барихад тодорхой яригдана. Хязгаар хуулиараа 60 хувь байх ёстой гэсэн хязгаар тавьж байгаа. Энэ бол хуулиараа орж ирж байгаа ийм л тоо.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм ээ. Энэ дээр бол ойлголтын зөрөө байхгүй. Хуулийн хязгаар 60 байж болох нь дээд хэмжээ. Тэгэхээр бодит байдал чинь 51-тэй байхад бид заавал 60 гэж тавьчхаад улс амьтныг үймүүлээд байх хэрэггүй байхгүй юу даа. Бодит тоогоороо тавиад тов тодорхой мэдээлэл юмнуудаа гаргаад, тэгээд ер нь яг эндээ багтаад тэр төсвийн боловсруулалтынхаа үйл явцыг хийгээд явах нь өөрөө зохистой зүйл ээ. Тийм учраас би энэ тоогоо бууруулах юм биш үү гэсэн ийм саналтай байна.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний бас хэлээд байгаа асуудал яах вэ гол асуудал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн асуудал. Төсвийн тогтвортой байдлынхаа хуулийн хүрээнд тусгай шаардлагууд байгаа. Төсвийн алдагдал, өрийн хязгаар энэ өөрөө төсвийнхөө тогтвортой байдлыг хангах, цаашид бид нар урт хугацаандаа бас нэг талдаа энэ төсвийнхөө удирдлагыг зөв менежментийг хэрэгжүүлэх л гол зохицуулалтын асуудлууд л байгаад байгаа юм. Тэгээд үндсэндээ бид нар эдийн засгийн ийм цонх үе гарч ирж байгаа. Экспорт нэмэгдэж байгаа. Түүхий эд бүтээгдэхүүний хэмжээ болоод үнэ боломжийн байгаа энэ цаг үе дээр бол энэ өрийг хязгаарлах, алдагдлыг бууруулах л асуудлыг л бас ингэж яриад байна л даа. Тэгэхээр бид нарын хувьд бол гол зарчмын асуудал бол энэ гэж бодоод байгаа юм. Үндсэндээ боломж бололцоо байгаа бол 49-тэй гэж байгаа бол энийг 60 хувиар гэж дээд хязгаарт нь түлгэж дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцах энэ өрнийхөө хязгаарыг боломжийнхоо хэмжээнд нөөц бололцоондоо тулгуурлаад бууруулбал яасан юм бэ л гэсэн ийм санал байгаад байгаа юм.

Бид нар нэг талдаа энэ өрийг өрөөр санхүүжүүлдэг энэ тогтолцоог

яах вэ халах шаардлагатай л гэдэг асуудлыг бол бас л ярьж л байгаа. Эрсдэл бол бодитойгоор бид нарт бас байгаа. Тэгэхээр яах вэ, нийг тогтвортой байдлаа хангах үүднээс энэ дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааны дээд хязгаарыг нь хуулиар баталснаас нь доошоо дахиж батлах боломж бололцоо бол байна гэдэг асуудал яваад байгаа юм. Нэгдүгээрх нь. Тэгэхээр энэ дээр та бас тодорхой тайлбар өгөөч.

2-т удахгүй ингээд 2024 оны төсвийн төслийг өргөн барина. Хуулиараа 10 сарын 1-ээс өмнө, дотор өргөн барих үүрэгтэй байгаа. Тэгэхээр жил жилийн бас төсөв өргөн барихаар жил жилийн тодотгол хийгдэхэд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилдөг бас нэг буруу гажиг жишиг байгаад байдаг. Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол нэг талдаа Монгол Улсын төсөв, санхүүгийн дунд хугацааны бодлогын баримт шиг энийг бид нар бас хэлбэлзэлгүй сахиж байх ёстой, мөрдөж байх ёстой асуудлууд байдаг. Тэгэхээр энэ оны хувьд ирэх оны төсөв өргөн баригдахад гэдэг юм уу 10 сарын 1-ний дотор 2024 төсөв өргөн баригдахад төсвийн хүрээнд өөрчлөлт оруулахгүйгээр оруулж ирэх шаардлага бол байгаа. Энэ дээр та хэд маань бас ямар байр суурьтай байна. Байр сууриа илэрхийлээч гэх гэсэн юм. Жавхлан сайд. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Нэгэнт ингээд төсвийн хүрээний мэдэгдэл маань Их Хурлаар батлагдчихвал бид энэ хүрээндээ л одоо төсвөө төлөвлөж оруулж ирнэ дээ.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ чинь ирэх жилийн төсөв 2024 оных тийм ээ. Яах вэ, нийгмийн цалин тэтгэвэр гээд л юм явах байх. Эмнэлэг, эрүүл мэнд рүү ер нь яаж хуваарилалт явагдах гэж байна. Одоо энэ хавдрын эмнэлэг гээд бүх хаалга

үүдэнд нь очроор дүүрчихсэн, хүн нь багтахаа байчихсан, өвчтөн нь багтахаа байчихсан, үйлчлүүлэгчид нь багтахаа байчихсан нэг юм байгаа юм. Энэ рүү яам нь болохоор 160 тэрбум орчим төгрөг байхад бид нар бол бэлэн, зураг, төсөвтэй, тооцоотой гээд ингэдэг. Ер нь яг эрүүл мэндийн чиглэл, ер нь зөвхөн хавдрын эмнэлэг гэлтгүй Эх нялхсын төв, хүүхдийн эмнэлгүүд байна. Энэ 3 дахь шатлалын эмнэлгүүд дээр байгаа очер дарааллын юмнууд ер нь яах юм. Яг урд өмнөх шигээ байгаа юу, эс үгүй бол энийгээ жоохон арай өөрчилсөн байдлаар юм хийх үү. Яг зүгээр өмнөх жилүүдийнх шигээ төсвийн төсөөлөл хийх юм бол ерөнхий том дүнгээрээ л наадах чинь нэг эрүүл мэндийнх нь яг хөдөлсөн юм уу. Энийг нэг асуумаар байна.

2 дугаарт энэ орон нутгууд руу явж байгаа нутгийн зам гээд нэг хөтөлбөр явагдсан. Аймгуудыг сумтай нь холбоно гээд. Тэгээд тэр дээр яг тодорхой ийм ийм хөтөлбөрөөс ч гэдэг юм уу, ийм ийм байдлаар санхүүжилтийг нь бид нар шийднэ гэсэн тийм төсөөлөл энэ дотор чинь байна уу. Нийгэм бол үнийн өсөлт, цалин тэтгэвэр гээд орлогын хомсдолтой байна. Төгрөгийн ханиш унасан, дагаад энэ бараа бүтээгдэхүүний үнэ өссөн гээд олон юмнууд л байх шиг байна. Үүнээс гадна энэ төрөөс үзүүлэх суурь үйлчилгээний зүйлүүд дээрээ тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт чинь туссан байгаа томоохон зорилт байгаа шүү дээ. Тэр зам дэд бүтцийн хөгжлийн асуудал. Энэ юмнууд энэ төсөөлөлдөө ер нь хэр сууж явсан юм бол. Бид нар чинь одоо хүмүүст таалагдах гэж явсаар байгаад энэ улс орон гэдэг өөрийнх нь авч явж байгаа том юмнууд дээр бодлогын юмнууд дээр бас их дутуу анхаараад байх шиг л харагдаад байгаа юм. Энэ дээр тоо баримт юу байна. Өмнө жишээ нь төсөв дагуулахдаа орж ирээд л засаад л оруулж ирдэг. Тэр байдал чинь бол ирэх жил гарахгүй юм байна л гэж ойлголоо шүү дээ. Тэгэхээр одоо энэ тоон дээр чинь сайн нягтлахгүй бол ирэх жил

эргээд гишүүд ямар нэгэн юм ярихад бол төсөөллийг бид нар ингэж баталсан учраас гээд энэ хайрцагт л яг дагах гээд байна шүү дээ. Миний ойлгож байгаа зөв үү.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд асуултад хариулъя.

Б.Жавхлан: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Бид, Сангийн яамнаас өргөн барьж байгаа энэ тоонууд маань төсвийн хүрээний хязгаар 9 тоо л байгаа юм. Энд хөрөнгө оруулалттай холбоотой та асуулт тавьж байна. Хязгаарууд дундаа бид 5,8 их наядын хөрөнгө оруулалтын ийм боломж байна гэдэг ийм хязгаар тоогоо танилцуулж байна.

Хажуугийн танхимд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн дагуу 2024 оны хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын жагсаалтууд яг ид хэлэлцэгдэж байна. Тэндээс төлөвлөгөө батлагдаад гараад ирэхээр бид төлөвлөгөөний дагуу энэ төсвийнхөө хязгаарт багтаагаад хөрөнгө оруулалтуудаа хийх ийм хуулийн зохицуулалттай явж байгаа. Тэгэхээр одоо нэг бүрчлэн ярих нь бол эдийн засгийнхаа төлөвлөгөө дээр яригдана. Бид бол хязгаар тоогоо бол батлуулж байгаа ийм асуудал байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байхгүй байна. Бичгээр ирсэн санал байхгүй байна. Байна уу. Үг байхгүй шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал байгаа юм уу. Батжаргал гишүүн саналаа танилцуулъя.

Ж.Батжаргал: Тэгэхээр ийм л байгаад байна л даа. 2 л зүйл байгаад байгаа юм.

1 дүгээрт нийт зарлагын дээд хязгаарын асуудал байгаад байгаа юм. Энэ хүүхдийн мөнгөний асуудлыг бид 2022 оныхоо зарчмаар явмаар байгаа юм.

Хүүхдийнхээ хөгжлийг дэмжиж байна гэж үзэж ирээдүйн өв сан дээрээ авч 1,6 орчим их наядаа тэндээ шингээгээд, тэр дотроо тэр төсөв боловсруулах үйл явцынхаа хүрээнд дагуулж орж ирэх шийдвэрүүдээ яриад хэдэн хувийг нь хуримтлалаар нь үлдээх юм, хэдийг нь одоогийн байдлаар өгөх юм энэ тэр гэдэг асуудлаа зөв шийдэх юм бол төсөв дээрээс 1,6 их наядын юу буурах бололцоо байгаа. Үүнийг бол би ингэж шийдмээр. Тийм учраас би энэ хэмжээгээр нь төсвийнхөө зардал талын асуудлыг бууруулаад, тэгээд тэнцлээ сайжруулах үйл явцаа хийчих бололцоо байгаа юм байна гэж ингэж харж байгаа.

2 дахь миний зарчмын зөрүүтэй байгаа санаа бол 60 хувь гэдэг энэ хуулийн хязгаарын боломжит тоог бодит амьдрал руу нь оруулж ирэх ёстой. Тийм учраас би Засгийн газрын гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 51 хувиар нь барих ёстой юм байна. Тэгж байж энэ өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ өсөлтөөр бидний хэрэгцээ шийдэгдэх юм байна. Засгийн газраас өөрийнх нь оруулж ирсэн саналаар бол тэртээ тэргүй 49 хувь гээд явж байгаа учраас нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь бол өөрчлөгдөхгүй гарч болох юм байна. Тийм учраас 51 гэдгээр тодорхой батлах ёстой. Ингэж байж бид иргэд, олон түмнийг зөв мэдээлэлтэй болно. Энэ Улсын Их Хурал энэ улсынхаа төсөв энэ тал дээр баримталж байгаа бодлого юмнууд нь бас нэг тийм ирээдүйгээ харсан, хариуцлагатай байдлыг сайжруулсан ийм чиг хандлага болж харагдах ёстой. Үүгээрээ дамжиж төсөв боловсруулалтын үйл явц маань ч яг энэтэйгээ уялдаж явах ёстой гэсэн ийм байр суурьтай байна. Ийм санал гаргаж байна.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргалаа. Батжаргал гишүүний гаргасан саналтай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй санал хэлж болно. Жавхлан сайд тайлбар хэлэх

үү. Батсуурь гишүүн үг хэлж болно. Дэмжсэн, дэмжээгүй гэж болно. Томьёоллыг нь би дахиад уншаад өгье. Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Үгүй ээ, би нөгөө асуулт, үг хамт гэж бодсонгүй. Энэ Сангийн яамныхныгаа бас завтай, бүрэн байгаа дээр нь нэг зүйлийг анхааруулж хэлье гэж бодсон юм. Хязгаар дотроо нөгөө хөрөнгө оруулалтын асуудлууд яригдаад ирнэ. Бүрэн байгаа дээрээ яаж байна. Хэлэхээ больчих юм уу. Тэгвэл завгүй байгаа бол. 2022 онд Засгийн газрын тэргүүн орон нутагт яваад орон нутгаас санал авсан юм. Бүр ингээд албан ёсоор ард иргэдээс санал аваад, дараалал тогтоод, тэгээд эхний 5 асуудлуудыг 2023 оны төсөвт суулгая гэж ингэж тохирсон юм. Тэгээд 2023 онд чинь нөгөө шинээр зүйл байгаагүй учраас хөрөнгө оруулалт өнжчихсэн. Тийм учраас яг энэ Засгийн газрын тэргүүний орон нутагт яасан юмнуудыг очингуут байнга асуудаг, лавладаг, захиргаа, эрчим хүчний өргөтгөл, тэгээд л Дулааны станцын өргөтгөл ч гэдэг юм уу эхний 10-аад асуудал гаргаад тэгээд эхний 5-ыг бол зайлшгүй 2023 оны хөрөнгө оруулалтаар тавина гэсэн. Тийм болохлоор энэ төсвийн хязгаарлалтдаа тэр 5.8 их наядын хөрөнгө оруулалтад бол энийг бас бодлогоор оруулахыг Дэлгэржаргал дарга аа, онцгой анхаармаар байна. Тэгэхгүй бол очих болгонд л нөгөө Засгийн газрын тэргүүний амласан зүйл хаа байна вэ. Тэр ер нь эхэлж байна уу, эхлэхгүй байна уу гэсэн ийм зүйлүүд байгаа юм. Тэгэхлээр энийг бас нэг хэлчихье гээд. Сая би нөгөө асуулт, үг байхгүй юм байна гэж энэ агуулгаар нь хэлчихье гэж ойлгочихно. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн саналаа тайлбарлая.

Ж.Батжаргал: Хязгаар ярьж байгаа. Энэ асуудал нь өргөн баригдаж орж ирээгүй гэдэг ийм тайлбар өгдгөө болих ёстой манайхан. Дэг биш ээ,

уучлаарай. Тийм юм байхгүй байхгүй юу. Бид нар хязгаар ярьж байгаа ухаантай юм бол төсөөллөө харсан байдаг юм байгаа биз дээ. Тийм учраас энэ талаасаа хандмаар.

Тийм учраас би 1 дүгээр саналаа татчихъя. Тэр нийт зардлыг бууруулж тэнцэл сайжруулах гээд байгаагаа татчихъя. Төсөв боловсруулах үйл явцад үүнийг харин хатуу барих ёстой, үүнийг энэ Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдааны тэмдэглэлд нь үлдээе.

2 дахь саналаа бол санал хураана. Засгийн газрын өрийг 51-ээр нь байлгахгаар санал хурааж өгөөч гэж.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг унишиж танилцуулъя.

1 дүгээр зүйл. Засгийн газрын өрийн нийт хэмжээг 2024-2026 онуудад “60 хувь” гэснийг “51 хувь” болгож бууруулах. Үүнийг дагалдуулан мөнгөн дүнг бууруулах гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна.

Санал хураалтыг явуулъя. Зарчмын зөрүүтэй саналаар, саяын гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэдэг байдлаар санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалт 28,6 хувиар биш 71,4 хувиар дэмжигдсэнгүй ээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин гишүүн нэгдсэн чуулганд танилцуулна. Ингээд Төсвийн байнгын хорооны хуралдаанаар

хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Баярлалаа.

09.52 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ